



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/62

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
3 дугаар сургуулийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Шинэ зууны эрдмийн өргөө ТББ-аас хандиваар өгсөн нийт 4,560,000.0 (дөрвөн сая таван зуун жаран мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль (В.Хоролгарав)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль (В.Хоролгарав)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст (Г.Тэмүүжин)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500263

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн 182 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 3-р сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	ТОО ХЭМЖЭЭ		Бүртгэлийн анхны үнэ /тегерегер/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр	
						Хэмжих нэгж	Тоо	нэгжийн үнэ	нийт дүн			
Тавилга, эд хогшил												
1	Ширээ	Модон, пумбочикатай	2024	Сайн	Ш	1		550,000	550,000			
2	Кресло	Хос саарал өнгөтэй	2024	Сайн	Ш	1		650,000	650,000	Шинэ зууны эрдмийн өргөө ТББ	Хандив	
3	Сандал	Арьсан бүрээстэй никель хөлтэй	2024	Сайн	Ш	42		80,000	3,360,000			
Тавилга, эд хогшлын дүн										4,560,000		